



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МАЛЫН УДМЫН САНГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН  
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/349/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер С.Нацагдорж  
Утас: 261628 Цахим хаяг: [natsagdorjs@audit.gov.mn](mailto:natsagdorjs@audit.gov.mn)  
Аудитор Л.Мөнхцацрал  
Утас: 261740 Цахим хаяг: [munkhtsatsrall@audit.gov.mn](mailto:munkhtsatsrall@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Дундманхайдай аудит”ХХК  
Захирал Ж.Бямбажав  
Утас: 11-325262 Цахим хаяг: [dum\\_audit@yahoo.com](mailto:dum_audit@yahoo.com)

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	14
3. Аудитын тайлан .....	15
3.1 Ерөнхий зүйл .....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	17
3.4 Материаллаг байдал .....	17
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	18
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	19
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	20
3.8 Аудитын гол асуудал .....	20
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	20
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	21
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	21
4. Аудитын илрүүлэлт .....	22
4.1 Залруулсан алдаа .....	22
4.2 Төлбөрийн акт .....	22
4.3 Албан шаардлага .....	22
4.4 Зөвлөмж .....	22
5. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл .....	23

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
НА	Нотлох баримт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



МАЛЫН УДМЫН САНГИЙН ҮНДЭСНИЙ  
ТӨВИЙН ЗАХИРАЛ П.ГАНХУЯГ ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07/414  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Малын удмын сангийн үндэсний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Малын удмын сангийн үндэсний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагын хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



**2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>7,034,402,027.01</b>	<b>8,326,182,555.42</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	3,503.00
<b>311</b>	<b>Кассад байгаа бэлэн мөнгө</b>	-	3,503.00
31110	Төгрөг	-	3,503.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>2,725,420,369.09</b>	<b>799,149,619.20</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	36,960.50	1,293,216.61
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>2,725,383,408.59</b>	<b>797,856,402.59</b>
3351	Байгууллагаас авах авлага	2,478,063,239.45	488,106,239.45
3352	Хувь хүмүүсээс авах авлага	209,988,674.04	273,313,768.04
33530	Ажилчдаас авах авлага	37,331,495.10	36,436,395.10
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	12,800,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	12,800,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>4,308,981,657.92</b>	<b>7,514,229,433.22</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>164,873,054.76</b>	<b>164,363,538.36</b>
35110	Тусгай зориулалттай материал	164,812,334.76	164,363,538.36
35130	Эм боох материал	60,720.00	-
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,264,943,705.39	1,116,417,705.07
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>119,361,433.56</b>	<b>108,536,294.10</b>
35410	Бичиг хэргийн материал	139,000.00	-
35420	Аж ахуйн материал	37,932,810.00	48,262,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,578,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	53,956,852.06	188,715.20
35460	Хүнсний материал	515,825.00	-
35470	Бусад хангамжийн материал	24,238,946.50	60,085,078.90
<b>35600</b>	<b>Мал амьтад</b>	<b>2,759,803,464.21</b>	<b>6,124,911,895.69</b>
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>17,251,345,808.86</b>	<b>16,566,350,954.47</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>17,251,345,808.86</b>	<b>16,566,350,954.47</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>16,360,006,696.36</b>	<b>15,783,298,821.19</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	14,531,830,823.49	14,510,509,919.37
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,281,003,374.60)	(1,763,832,928.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	339,775,168.60	360,555,519.60
39204	Хуримтлагдсан элэгдэл	(223,222,884.35)	(229,494,086.65)
39205	Машин тоног төхөөрөмж	3,746,090,086.06	3,713,835,383.76
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,223,984,740.42)	(1,241,751,105.93)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	578,896,351.49	555,091,897.04
39208	Хуримтлагдсан элэгдэл	(220,603,110.85)	(267,398,833.21)
39214	Бусад үндсэн хөрөнгө	178,242,924.00	217,212,524.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(96,256,191.46)	(101,671,112.91)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	30,241,644.40	30,241,644.40
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>891,339,112.50</b>	<b>783,052,133.28</b>
39301	Программ хангамж	5,626,000.00	5,626,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,205,687.50)	(3,992,666.72)
39303	Бусад биет бус хөрөнгө	888,918,800.00	781,418,800.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>24,285,747,835.87</b>	<b>24,892,533,509.89</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>97,745,857.36</b>	<b>130,318,725.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>97,745,857.36</b>	<b>130,318,725.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>97,745,857.36</b>	<b>130,318,725.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	7,455,542.36	728,960.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	29,914,000.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>90,290,315.00</b>	<b>99,675,765.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	90,290,315.00	99,595,765.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	80,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>24,188,001,978.51</b>	<b>24,762,214,784.89</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>24,188,001,978.51</b>	<b>24,762,214,784.89</b>

Малын удмын сангийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,604,070,935.15	1,496,570,935.15
51101	Өмч: - төрийн	1,604,070,935.15	1,496,570,935.15
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>21,974,996,678.96</b>	<b>22,678,030,389.46</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	22,782,561,060.69	21,996,317,583.08
51220	Тайлант үеийн үр дүн	(807,564,381.73)	681,712,806.38
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	608,934,364.40	587,613,460.28
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>24,285,747,835.87</b>	<b>24,892,533,509.89</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,105,089,243.00</b>	<b>2,652,859,814.56</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>255,867,943.00</b>	<b>1,979,863,914.56</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	255,867,943.00	1,979,863,914.56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	255,867,943.00	1,979,863,914.56
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,512,000.00	34,679,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,978,000.00	10,569,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	238,377,943.00	1,934,615,614.56
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>849,221,300.00</b>	<b>672,995,900.00</b>
<b>1310</b>	Улсын төвлөрсөн төсвөөс	817,708,200.00	661,433,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	817,708,200.00	661,433,900.00
<b>1311</b>	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,513,100.00	11,562,000.00
131104	Дээд шатны төсвөөс доод шатны төсвийн захирагчид	11,213,100.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого	20,300,000.00	11,562,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,924,971,677.35</b>	<b>1,856,077,419.44</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,924,971,677.35</b>	<b>1,856,077,419.44</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,856,232,942.69</b>	<b>1,792,752,460.50</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>427,264,981.32</b>	<b>453,658,165.53</b>
210101	Үндсэн цалин	379,751,262.32	343,923,838.00
210102	Нэмэгдэл	39,143,719.00	55,652,870.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,370,000.00	54,081,457.48
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>52,353,535.86</b>	<b>51,166,479.40</b>
210201	Тэтгэврийн даатгал	36,456,853.03	34,055,351.49
210202	Тэтгэмжийн даатгал	4,281,198.36	4,628,525.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,340,963.09	3,598,680.92
210204	Ажилгүйдлийн даатгал	746,122.25	815,780.23
210205	Эрүүл мэндийн даатгал	7,528,399.13	8,068,141.60
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>44,468,068.80</b>	<b>63,870,760.30</b>
210301	Гэрэл, цахилгаан	30,039,050.80	31,570,535.30
210302	Түлш, халаалт	-	17,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,869,018.00	4,740,225.00
210304	Байрны түрээс	10,560,000.00	10,560,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>115,832,604.83</b>	<b>136,655,618.28</b>
210401	Бичиг хэрэг	3,144,000.00	4,445,280.00
210402	Тээвэр, шатахуун	86,608,605.14	83,342,799.86
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,672,749.62	4,233,606.42
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,407,250.07	768,932.00
210408	Бараа материал акталсны зардал	-	43,865,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>10,123,530.00</b>	<b>13,455,962.60</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,998,180.00	8,449,370.00
210502	Хоол, хүнс	3,125,350.00	5,006,592.60



**Малын удмын сангийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,510,730.00</b>	<b>-</b>
210604	Урсгал засвар	6,510,730.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,895,000.00</b>	<b>12,328,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,895,000.00	12,328,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>247,247,038.42</b>	<b>189,343,972.94</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	246,831,908.42	188,921,442.94
210803	Даатгалын үйлчилгээ	115,830.00	115,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	277,300.00	262,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	44,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>948,537,453.46</b>	<b>872,273,001.45</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	316,755,608.31	241,650,224.40
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	631,781,845.15	630,622,777.05
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>68,738,734.66</b>	<b>63,324,958.94</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>56,000,083.80</b>	<b>42,485,400.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	54,300,083.80	40,985,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,700,000.00	1,500,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>12,738,650.86</b>	<b>20,839,558.94</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,738,650.86	20,839,558.94
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>(819,882,434.35)</b>	<b>796,782,395.12</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>146,156,222.08</b>	
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	46,156,222.08	-
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>133,838,169.46</b>	<b>115,069,588.74</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	133,838,169.46	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	115,069,588.74
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>	<b>12,318,052.62</b>	<b>(115,069,588.74)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(807,564,381.73)</b>	<b>681,712,806.38</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

<i>2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон</i>				<i>/төгрөгөөр/</i>
<b>Үзүүлэлт</b>	<b>Засгийн газрын оруулсан капитал</b>	<b>Дахин үнэлгээний нөөц</b>	<b>Хуримтлагдсан дүн</b>	<b>Засгийн газрын хувь оролцооны нийт дүн</b>
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,604,070,935.15	608,934,364.40	22,777,002,054.93	24,990,007,354.48
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	5,559,005.76	5,559,005.76
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,604,070,935.15</b>	<b>608,934,364.40</b>	<b>22,782,561,060.69</b>	24,995,566,360.24
Тайлант үеийн үр дүн	-	-	(807,564,381.73)	(807,564,381.73)
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,604,070,935.15</b>	<b>608,934,364.40</b>	<b>21,974,996,678.96</b>	24,188,001,978.51
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,604,070,935.15</b>	<b>608,934,364.40</b>	<b>21,974,996,678.96</b>	24,188,001,978.51
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	21,320,904.12	21,320,904.12
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	(107,500,000.00)			(107,500,000.00)
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	(21,320,904.12)	-	(21,320,904.12)
Тайлант үеийн үр дүн	-	-	681,712,806.38	681,712,806.38
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,496,570,935.15</b>	<b>587,613,460.28</b>	<b>22,678,030,389.46</b>	<b>24,762,214,784.89</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,158,450,832.10</b>	<b>1,011,353,814.60</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>309,229,532.10</b>	<b>328,745,914.60</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>309,229,532.10</b>	<b>328,745,914.60</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>309,229,532.10</b>	<b>328,745,914.60</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	106,413,520.00	133,625,007.65
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	202,816,012.10	195,120,906.95
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>849,221,300.00</b>	<b>682,607,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>817,708,200.00</b>	<b>661,433,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	817,708,200.00	661,433,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>31,513,100.00</b>	<b>21,174,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс доод шатны төсвийн захирагчид	11,213,100.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд нэмэлт орлого	20,300,000.00	21,174,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,157,350,925.95</b>	<b>1,010,070,311.60</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,157,350,925.95</b>	<b>1,010,070,311.60</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,088,612,191.29</b>	<b>946,745,352.66</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>387,809,177.02</b>	<b>402,364,399.00</b>
210101	Үндсэн цалин	270,780,902.92	291,084,206.02
210102	Нэмэгдэл	88,596,439.19	58,406,099.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,431,834.91	52,874,093.48
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>52,036,814.60</b>	<b>53,578,760.99</b>
210201	Тэтгэврийн даатгал	36,581,593.69	38,084,599.74
210202	Тэтгэмжийн даатгал	3,919,392.51	3,923,599.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,122,066.92	3,138,899.96
210204	Ажилгүйдлийн даатгал	765,061.76	774,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,648,699.72	7,656,961.55
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>157,030,058.80</b>	<b>105,226,160.30</b>
210301	Гэрэл, цахилгаан	30,039,050.80	31,570,535.30
210302	Түлш, халаалт	112,511,990.00	59,886,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,919,018.00	4,740,225.00
210304	Байрны түрээс	10,560,000.00	9,029,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>34,196,559.62</b>	<b>20,049,176.42</b>
210401	Бичиг хэрэг	2,981,700.00	2,385,400.00
210402	Тээвэр, шатахуун	10,338,000.00	7,216,470.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,672,749.62	4,233,606.42
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,204,110.00	6,213,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>600,000.00</b>	<b>2,200,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	2,200,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>126,001,530.00</b>	<b>8,042,180.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	108,159,400.00	1,185,000.00
210604	Урсгал засвар	17,842,130.00	6,857,180.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,162,380.00</b>	<b>13,726,922.00</b>
210702	Дотоод албан томилолт	6,162,380.00	13,726,922.00

Малын удмын сангийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>317,682,471.25</b>	<b>332,586,553.95</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	316,867,341.25	321,364,023.95
210803	Даатгалын үйлчилгээ	115,830.00	115,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	277,300.00	262,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	10,800,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,093,200.00</b>	<b>8,971,200.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,093,200.00	8,971,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>68,738,640.81</b>	<b>63,324,958.94</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>56,000,083.80</b>	<b>42,485,400.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	54,300,083.80	40,985,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,700,000.00	1,500,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>12,738,650.86</b>	<b>20,839,558.94</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,738,650.86	20,839,558.94
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>1,099,906.15</b>	<b>1,283,503.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,100,000.00</b>	<b>1,280,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,100,000.00</b>	<b>1,280,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,100,000.00</b>	<b>1,280,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,100,000.00	1,280,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(1,100,000.00)</b>	<b>(1,280,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(93.85)</b>	<b>3,503.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>93.85</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>3,503.00</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,016,865,600.00</b>	<b>969,336,782.66</b>	<b>(47,528,817.34)</b>	<b>95.3</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,016,865,600.00</b>	<b>969,336,782.66</b>	<b>(47,528,817.34)</b>	<b>95.3</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>972,550,200.00</b>	<b>926,851,382.66</b>	<b>(45,698,817.34)</b>	<b>95.3</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>402,364,400.00</b>	<b>402,364,399.00</b>	<b>(1.00)</b>	<b>100.0</b>
210101	Үндсэн цалин	295,459,900.00	291,084,206.02	(4,375,693.98)	98.5
210102	Нэмэгдэл	51,435,800.00	58,406,099.50	6,970,299.50	113.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	55,468,700.00	52,874,093.48	(2,594,606.52)	95.3
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>54,369,100.00</b>	<b>53,578,760.99</b>	<b>(790,339.01)</b>	<b>98.6</b>
210201	Тэтгэврийн даатгал	38,674,600.00	38,084,599.74	(590,000.26)	98.5
210202	Тэтгэмжийн даатгал	3,923,600.00	3,923,599.74	(0.26)	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,138,900.00	3,138,899.96	(0.04)	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	784,700.00	774,700.00	(10,000.00)	98.7
210205	Эрүүл мэндийн даатгал	7,847,300.00	7,656,961.55	(190,338.45)	97.6
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>108,668,800.00</b>	<b>105,226,160.30</b>	<b>(3,442,639.70)</b>	<b>96.8</b>
210301	Гэрэл, цахилгаан	34,997,000.00	31,570,535.30	(3,426,464.70)	90.2
210302	Түлш, халаалт	59,886,000.00	59,886,000.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	4,756,400.00	4,740,225.00	(16,175.00)	99.7
210304	Байрны түрээс	9,029,400.00	9,029,400.00	-	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>18,635,900.00</b>	<b>14,637,206.42</b>	<b>(3,998,693.58)</b>	<b>78.5</b>
210401	Бичиг хэрэг	3,092,600.00	1,885,400.00	(1,207,200.00)	61.0
210402	Тээвэр, шатахуун	7,833,100.00	6,079,500.00	(1,753,600.00)	77.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,548,500.00	4,233,606.42	(314,893.58)	93.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,161,700.00	2,438,700.00	(723,000.00)	77.1
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,000,000.00</b>	<b>2,200,000.00</b>	<b>(800,000.00)</b>	<b>73.3</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,000,000.00	2,200,000.00	(800,000.00)	73.3
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>28,342,600.00</b>	<b>8,042,180.00</b>	<b>(20,300,420.00)</b>	<b>28.4</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,424,000.00	1,185,000.00	(13,239,000.00)	8.2
210604	Урсгал засвар	13,918,600.00	6,857,180.00	(7,061,420.00)	49.3
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,365,100.00</b>	<b>6,364,922.00</b>	<b>(178.00)</b>	<b>100.0</b>
210702	Дотоод албан томилолт	6,365,100.00	6,364,922.00	(178.00)	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>341,827,000.00</b>	<b>325,466,553.95</b>	<b>(16,360,446.05)</b>	<b>95.2</b>

Малын удмын сангийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	328,661,000.00	314,244,023.95	(14,416,976.05)	95.6
210803	Даатгалын үйлчилгээ	185,500.00	115,830.00	(69,670.00)	62.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	366,500.00	262,700.00	(103,800.00)	71.7
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	198,000.00	44,000.00	(154,000.00)	22.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	10,800,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	1,616,000.00	-	(1,616,000.00)	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8,977,300.00</b>	<b>8,971,200.00</b>	<b>(6,100.00)</b>	<b>99.9</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,977,300.00	8,971,200.00	(6,100.00)	99.9
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>44,315,400.00</b>	<b>42,485,400.00</b>	<b>(1,830,000.00)</b>	<b>95.9</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>44,315,400.00</b>	<b>42,485,400.00</b>	<b>(1,830,000.00)</b>	<b>95.9</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,985,400.00	40,985,400.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,330,000.00	1,500,000.00	(1,830,000.00)	45.1
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,016,865,600.00</b>	<b>969,340,285.66</b>	<b>(20,839,528.94)</b>	<b>97.9</b>
<b>1320</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>661,433,900.00</b>	<b>640,594,371.06</b>	<b>(20,839,528.94)</b>	<b>96.9</b>
122005	Төсвөөс санхүүжих	661,433,900.00	640,594,371.06	(20,839,528.94)	96.9
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>355,431,700.00</b>	<b>328,745,914.60</b>	<b>-</b>	<b>100.0</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	160,310,793.55	133,625,007.65	-	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	195,120,906.95	195,120,906.95	-	100.0
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
			-	-	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>				
			-	3,503.00	3,503.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>				
		1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>				
		34	34	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	29	29	-	100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>21,174,000.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ		21,174,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		21,174,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		5,411,970.00
210401	Бичиг хэрэг		500,000.00
210402	Тээвэр, шатахуун		1,136,970.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		3,775,000.00
2105	Нормативт зардал		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2107	Томилолт зочны зардал		7,362,000.00
210702	Дотоод албан томилолт		7,362,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		8,400,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		8,400,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		30.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		30.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>21,174,000.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		21,174,000.00
131105	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131106	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		21,174,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Малын удмын сангийн үндэсний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад цалин хөлсний тооцоо, татвар, нийгмийн даатгалын тайланг үнэн зөв тайлагнах, бараа материал худалдан авах, ажил үйлчилгээний төлбөрийг И баримтаар баталгаажуулж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 25-аас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Дундманхайдай Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Батжаргал, Н.Тэмүүжин нар гүйцэтгэж, захирал Ж.Бямбажав хянан удирдаж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Цэвэлмаа хэрэгжүүлсэн.

Малын удмын сангийн үндэсний төв нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Малын удмын сангийн үндэсний төв нь мал сүргийг генийн түвшинд төрийн хамгаалалтад авч, малын үржлийн ажил, үйлчилгээнд биотехнологи, генийн инженерчлэлийн дэвшилтэт аргыг нэвтрүүлснээр малын ашиг шим, бүтээмжийг нэмэгдүүлэн мах, сүүний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, улмаар мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Малын удмын сангийн үндэсний төв нь мал сүргийг генийн түвшинд төрийн хамгаалалтад авч, малын үржлийн ажил, үйлчилгээнд биотехнологи, генийн инженерчлэлийн дэвшилтэт аргыг нэвтрүүлснээр малын ашиг шим, бүтээмжийг нэмэгдүүлэн мах, сүүний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, улмаар мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- ЗГ-ын 118 дугаар тогтоол “Төрийн байгууллагын үйл ажиллагааны түр горим тогтоох тухай”;
- Монгол Улсын Засгийн газрын хуралдааны 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 51 дүгээр тэмдэглэлээр Улсын төсөвт байгууллагын төсвийн захирагч нарт өгсөн



даалгавар, ЗГ-ын 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 269 дүгээр тогтоол "Хөрөнгө шилжүүлэх тухай";

- Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн А/108 дугаар тушаал "Малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх хөдөлгөөн өрнүүлэх тухай", мөн сайдын 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн А/72 дугаар тушаалаар баталсан "Мал бүртгэлжүүлэлтийн аян зохион байгуулах тухай" ажлын удирдамж;
- Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 3 дугаар 30-ны өдрийн "Үржлийн малд үзлэг ангилалт хийх, баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэх, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх" ажлын удирдамж.
- Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн А/253 дугаар тушаал "Үржлийн малын талаар авах зарим арга хэмжээний тухай" зэрэг тогтоол

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, санхүү, хөрөнгө оруулалтын газраас 2021 оны 5, 6 дугаар сард өр авлага барагдуулах, орон нутаг дахь цөм сүргийн салбар нэгжүүдийн мал сүргийг стандарт шаардлагад нийцүүлэн ангилж, заазлах, чанартай малаар бүрдүүлэх удирдамж, чиглэлийг албан бичгээр өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Малын удмын сангийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 1,015,361.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 15,230.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Малын удмын сангийн үндэсний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 606,785.7 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилгаа, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, засгийн газрын оролцоо данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	3.5	3.5
Авлага	2,725,420.4	799,149.6	(1,926,270.7)
Урьдчилгаа	0	12,800.0	12,800.0
Бараа материал	4,308,981.6	7,514,229.4	3,205,247.8
Үндсэн хөрөнгө	17,251,345.8	16,566,350.9	(684,994.9)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>24,285,747.8</b>	<b>24,892,533.5</b>	<b>606,785.7</b>
Богино хугацаат өр төлбөр	97,745.9	130,318.7	32,572.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,604,070.9	1,496,570.9	(107,500.0)
Хуримтлагдсан ашиг	21,974,996.7	22,678,030.4	703,033.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	608,934.4	587,613.5	(21,320.9)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>24,285,747.8</b>	<b>24,892,533.5</b>	<b>606,785.7</b>

Авлага дансны үлдэгдэл 799,149.6 мянган төгрөг болж 1,926,270.7 мянган төгрөгөөр буурсан нь Гачуурт ХХК-аас авах 2,000,000.0 мянган төгрөгийн авлагыг тайлант онд барагдуулсантай холбоотой байна. Авлага дансны үлдэгдэлд 2016-2019 онуудад үүссэн насжилт өндөртэй 488,106.2 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага, 273,313.7 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага байна.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 12,800.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хяналтын нэгдсэн онлайн платформын 2022 оны үйлчилгээний төлбөрийг урьдчилж төлснөөс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 7,514,229.4 мянган төгрөг болж, 3,205,247.8 мянган төгрөгөөр өссөн нь Хөдөө аж ахуйг дэмжих сангаас 835,387.6 мянган төгрөгийн сайн үүлдрийн 350 толгой хонь, 180,124.2 мянган төгрөгийн лимүзен үүлдрийн 29 толгой үхэр нийт 1,015,511.8 мянган төгрөгийн үнэ бүхий мал амьтад балансаас баланст шилжүүлж, Гачуурт ХХК-аас авах 2,000,000.0 мянган төгрөгийн малын авлага, үндсэн сүргээс төл малын нас дэвшилтээр 189,736.0 мянган төгрөгийн орлого авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 16,566,350.9 мянган төгрөг болж, 684,994.9 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 72, 73 дугаар тогтоолоор нийт 89,843.8 мянган төгрөгийн хөрөнгө акталсан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын А1/1453 дугаар албан бичгийн дагуу 107,500.0 мянган төгрөгийн үнэ бүхий Хөвсгөл аймгийн салбар нэгжийн конторын барилгын газрыг Хөвсгөл

Хүнс хөдөө аж ахуйн газарт балансаас баланст шилжүүлж, 487,651.1 мянган төгрөгийн тайлант үеийн элэгдлийн зардал байгуулсантай тус тус холбоотой байна.

Өглөгийн данс 130,318.7 мянган төгрөг болж, 32,572.8 төгрөгөөр өссөн нь түлш, халаалтын зардалтай холбоотой байна. Өглөгийн дансны үлдэгдлийн 90 хувь нь 2019 онд үүссэн 90,290.3 мянган төгрөгийн хадлангийн зориулалттай тоног төхөөрөмж зээлээр худалдан авсан зээлийн үлдэгдэл байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,496,570.9 мянган төгрөг болж, 107,500.0 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын А1/1453 дугаар албан бичгийн дагуу 107,500.0 мянган төгрөгийн үнэ бүхий Хөвсгөл аймгийн салбар нэгжийн конторын барилгын газрыг Хөвсгөл Хүнс хөдөө аж ахуйн газарт балансаас баланст шилжүүлсэнтэй холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүн 22,678,030.4 мянган төгрөг болж 703,033.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс урсгал санхүүжилтэд 661,433.9 мянга, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 355,431.7 мянга, нийт 1,016,865.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,016,865.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 1,016,865.6 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 661,433.9 мянга, үндсэн болон туслах үйл ажиллагааны 355,431.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, нийт 1,016,865.6 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 661,433.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны 328,745.9 мянга, нийт 990,179.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 969,336.8 мянган төгрөгийг зарцуулж, 20,839.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, 3.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд зааснаар тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлого 133,900.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагаанаас 221,531.7 төгрөг нийт 355,431.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 328,745.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 94.0 хувиар биелүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 969,336.8 мянган төгрөг буюу 95.3 хувьтай байгаа нь эд хогшил, урсгал засварын зардал 20,300.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 16,360.4 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70801	Мал аж ахуйг хөгжүүлэх	1,016,865.6	969,336.8	47,528.8	95.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансаар Төв аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газраас малын зохиомол хээлтүүлгийн 21,174.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 5,411.9 мянга, томилолтын зардалд 7,362.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 8,400.0 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 0.03 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ. Нэмэлт төсвийн орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын үйл ажиллагааны онцлог “Үндэсний хэмжээнд бий болгосон гений сан” бүхий мал, цөм сүргийг хамгаалах болон гэрээний дагуу ажиллаж байгаа малчны ажил үүргийг дүгнэх журам боловсруулан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлтээр санал оруулах талаар судлан бүртгэлийг тооцоог сайжруулан шинэчлэн оруулах шаардлагатай байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд нийт байршуулбал зохих 270,598.9 мянган төгрөгийн 42 мэдээллээс 166,160.4 мянган төгрөгийн 38 мэдээллийг байршуулж, 104,438.5 мянган төгрөгийн 6 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим системд мэдээллийг ил, тод байршуулах зөвлөмж хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Малын удмын сангийн үндэсний төвийн 2021 оны худалдан авалтын төлөвлөгөөг худалдан авах ажиллагааны сайтад хуулийн дагуу байршуулсан байна.

Тус төв нь 2021 оны А/30 дугаар тушаалаар үнэлгээний хороог 4 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан нээлттэй болон харьцуулалтын аргаар 201,403.0 мянган төгрөгийн худалдан авалтыг 100 хувь зохион байгуулж, гүйцэтгэлийн тайланг 2021 оны 6 дугаар албан бичгээр дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.

Байгууллагын хэмжээнд ажил, үйлчилгээний нийт 29 гэрээ хийгдсэнээс 26 гэрээ дүгнэх акт үйлдэж баталгаажуулсан байна.

Завсрын аудитаар холбогдох байгууллагуудад дараах асуудлыг шийдвэрлэхээр зөвлөмж өгсөн боловч тайлант хугацаанд шийдвэрлэгдээгүй байна. Улсын бүртгэлийн гэрчилгээнд дүрмийн сангийн хөрөнгийн дүн 1,422,600.6 мянган төгрөгийг нэмэлт өөрчлөлтийг хийгээгүй нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3. "хуулийн этгээдийн улсын бүртгэл" гэж хуулийн этгээдийн эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой хуульд заасан бүртгэлийн үйл ажиллагааг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцээгүй байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын бүртгэлийн гэрчилгээнд дүрмийн сангийн өөрчлөлтийг хийлгэх зөвлөмж өгсөн.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 5,183,205.5 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илрүүлснээс 375,812.6 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 104,438.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлагын санал хүргүүлж, 4,702,954.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 2,521,776.3 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангасан, 2,285,616.6 мянган төгрөгийг Улсын бүртгэлийн ерөнхий газар, Төрийн өмчийн хороонд шийдвэрлүүлэхээр албан бичиг хүргүүлсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6,700.0 мянган төгрөгийн албан шаардлагын биелэлтийг ханган, 10,873.7 мянган төгрөгийн 2 актыг барагдуулан, 22,760.0 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангасан байна. Аудитаар өгсөн нийт 40,333.7 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	10,873.7	2	10,873.7			
Албан шаардлага	1	6,700.0	1	6,700.0	-	-	100
Зөвлөмж	2	22,760.0	2	22,760.0	-	-	100
Нийт дүн	5	40,333.7	5	40,333.7			

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд ашиглаж байгаа боловч үлдэх өртөггүй 863,015.8 мянган төгрөгийн 337 нэр төрлийн хөрөнгийг холбогдох байгууллагад хүсэлт гаргаж

шийдвэрлүүлсэн байдал, улсын бүртгэлийн гэрчилгээнд 1,422,600.6 мянган төгрөгөөр дүрмийн санг нэмэгдүүлж хөрөнгийг шийдвэрлэсэн байдал, цөм сүргийн төслийн нэгжийн шатахуун зарцуулалт зэрэгт нарийвчилсан горим сорилыг дараагийн аудитаар хэрэгжүүлнэ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 680,990.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 670,970.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 173.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,292.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 7,553.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 10,019.5 мянган төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 15,230.4 мянган төгрөгөөс бага байгаа тул Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Тайлант хугацааны авлага, өглөгийн дансны гүйлгээг шалгахад 69,904.2 мянган төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдлийг шийдвэрлүүлэхээр шүүхийн шилжүүлж, шийдвэрлэгдэх шатанд байгаа;
- Бараа материалын тайланд 56,192.6 мянган төгрөгийн хөрөнгийг дутуу бүртгэсэн;
- Санхүүгийн байдлын тайлангийн бараа материалын эцсийн үлдэгдэл бараа материалын тодруулга тайлангийн эцсийн үлдэгдлээс 494,742.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан;
- Санхүүгийн байдлын тайлангийн бусад авлагын эхний үлдэгдэл 37,331.5 мянган төгрөг өмнөх оны аудитлагдсан тайлангаас зөрүүтэй, дансны төрөл буруу тусган нэгтгэснийг залруулсан;
- Программ хангамжийн үйлчилгээний гэрээний дагуу бэлтгэсэн 10,800.0 мянган төгрөгийн Төсвийн хяналтын нэгдсэн онлайн платформ, 2,000.0 мянган төгрөгийн веб сайтыг зардалд тайлагнасныг урьдчилж гарсан зардал бүртгэж залруулсан.

##### 4.2 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд 2 ажилтны ХХОАТ-ын 173.2 мянган төгрөгийн хөнгөлөлтийг давхардуулан тооцсон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Хувь хүнийн орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д “Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцсон татварын хөнгөлтийг суутгаж авахаар төлбөрийн акт тогтоов.

##### 4.3 Албан шаардлага

Аж ахуйн нэгж байгууллага болон малчидтай мал бойжуулах гэрээ хийж, байгуулсан гэрээг жилийн эцэст дүгнээгүй, 2,292.8 мянган төгрөгийн малын төлбөр тооцоог тооцоо нийлсэн актаар хугацаанд нь баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “.. бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтууд,

Оршин байх, Үнэн зөв байх, Иж бүрэн байх батламж мэдэгдлүүдтэй тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мал бойжуулах гэрээг дүгнэж, малын төлбөр тооцоог тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Татвар, нийгмийн даатгалын тайлантай холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

Цалингийн тооцооны хүснэгтээр олгосон цалингийн дүнг татварын тайлан, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлантай тулган шалгахад 27 албан хаагчийн цалин хөлсийг нийгмийн даатгалын, татварын тайланд 3,553.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д “Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэнтэй тус тус нийцэхгүй, Үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Анхан шатны баримт, тайланд үндэслэн холбогдох мэдээ, тайланг үнэн зөв бэлтгэж байх.

##### **2. Худалдан авалттай холбоотой асуудал**

###### **2.1 Илрүүлэлт:**

Тайлант хугацаанд хийгдсэн 4,000.0 мянган төгрөгийн зарим худалдан авалт болон ажил үйлчилгээний төлбөрийг И баримтгүй (*бэлтгэн нийлүүлэгч байгууллага И баримтыг цахим системд дутуу бүртгүүлсэн*) шилжүүлсэн.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14 “төлбөрийн баримт” гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтын заалтыг зөрчсөн.

###### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Бараа материал худалдан авах, ажил үйлчилгээний төлбөрийг И баримтаар баталгаажуулж ажиллах.

##### **3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

###### **3.1 Илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгийн дансанд ашиглаж байгаа боловч элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 863,015.8 мянган төгрөгийн 337 нэр төрлийн хөрөнгийг холбогдох байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлүүлээгүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн

захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэж заасантай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг цаашид ашиглагдах боломжгүй бол холбогдох дээд шатны байгууллагаар хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Малын удмын сангийн үндэсний төв	АХГ-2022/349/Н А-СТА-ТШЗ	Тайлант хугацаанд 2 албан хаагчид ХХОАТ-ын хөнгөлөлтийг давхардуулан тооцсоны улмаас нийт 173.2 мянган төгрөгийн ХХОАТ-ыг дутуу суутгасан байна.	Төлбөрийн акт тогтоов.	1	173.2			1	173.2				
2	Малын удмын сангийн үндэсний төв	АХГ-2022/349/Н А-СТА-ТШЗ	Аж ахуйн нэгж байгууллага болон малчидтай мал бойжуулах гэрээ хийж, байгуулсан гэрээг жилийн эцэст дүгнээгүй, 2,292.8 мянган төгрөгийн малын төлбөрийн тооцоог тооцоо нийлсэн актын дагуу хугацаанд нь барагдуулаагүй байна.	Албан шаардлага хүргүүлэв.	1	2292.8					1	2292.8		
3	Малын удмын сангийн үндэсний төв	АХГ-2022/349/Н А-СТА-ТШЗ	“Ногоон хуст” ХХК-иас 4,000.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй байна	Бараа материал худалдан авах, ажил үйлчилгээний төлбөрийг И баримтаар баталгаажуулж ажиллах.	1	4,000.00							1	4,000.0
4	Малын удмын сангийн үндэсний төв	2022/349/Н А-СТА-ТШЗ	Цалингийн тооцооны хүснэгтээр олгосон цалингийн дүнг татварын тайлан, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлантай тулган шалгахад 27 албан хаагчийн цалинг хөлсийг НДШ татварын тайланд 3,553.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	Ажиллагсдын цалинг холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв тооцож, татвар, нийгмийн даатгалын тайлантай тулгаж үлдэгдлийг баталгаажуулж ажиллах.	1	3,553.5							1	3,553.5

Малын удмын сангийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5	Малын удмын сангийн үндэсний төв	АХГ-2022/349/Н А-СТА-ТШЗ	Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 337 нэр төрлийн 863,015.8 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх.	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлэх.	1								1	-
6	Малын удмын сангийн үндэсний төв	АХГ-2022/349/Н А-СТА-ТШЗ	Дата ланд технологи ХХК-мэдээлэл технологи 10,800,000.00₮,МОНБЗ продакшн ХХК-2,000,000.00₮ вейб сайтын үнийг ББХ-өөр бүртгэлд тусгаагүй	Залруулга	1	12,800.00	1	12,800.0						
7	Малын удмын сангийн үндэсний төв	АХГ-2022/349/Н А-СТА-ТШЗ	Санхүүгийн байдлын тайлангийн бусад авлагын эхний үлдэгдэл 37,331,495.10 төгрөгөөр өмнөх оны аудитлагдсан тайлангаас зөрүүтэй тайлагнасан.	Залруулга	1	37,331.5	1	37,331.5						
8	Малын удмын сангийн үндэсний төв	АХГ-2022/349/Н А-СТА-ТШЗ	СБТ-ийн бараа материалын эцсийн үлдэгдэл бараа материалын тодруулга тайлангийн эцсийн үлдэгдэлтэй зөрүүтэй тайлагнасан	Залруулга	1	494,742.2	1	494,742.2						
9	Малын удмын сангийн үндэсний төв	АХГ-2022/349/Н А-СТА-ТШЗ	Бараа материалын тайланд 56,192.6 мянган төгрөгийн анхан шатны бүрдэл бүхий ажил гүйлгээг данс бүртгэлд тусгаагүй байна.	залруулга	1	56,192.6	1	56,192.6						
10	Малын удмын сангийн үндэсний төв	АХГ-2022/349/Н А-СТА-ТШЗ	Тайлант хугацааны авлага, өглөгийн дансны 69,904.2 мянган төгрөгийн үлдэгдлийг шийдвэрлэлт,тайлангийн үлдэгдэл зөрүүтэй, ББХ, бараа материал данс бүртгэлд тусгаагүй зэрэг зөрчлийг залруулсан.	залруулга	1	69,904.6	1	69,904.6						
<b>ДҮН</b>					<b>10</b>	<b>680,990.0</b>	<b>5</b>	<b>670,970.5</b>	<b>1</b>	<b>173.2</b>	<b>1</b>	<b>2292.8</b>	<b>3</b>	<b>7,553.5</b>

Малын удмын сангийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
1	Малын удмын сангийн үндэсний төв	АХГ-2022/349/Н А-СТА-ТШЗ	Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 104,438.5 мянган төгрөгийн 11 ажил, гүйлгээг шилэн дансны цахим системд хугацаа хоцроож байршуулсан байна.	Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийг тус тус мөрдөж ажиллах;	1						1			
2	Малын удмын сангийн үндэсний төв	АХГ-2022/349/Н А-СТА-ТШЗ	Улсын бүртгэлийн гэрчилгээ дэх дүрмийн сангийн хөрөнгийн дүнгээс санхүүгийн тайлангийн төрийн өмчийн дүн 1,422,600.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	Улсын бүртгэлийн гэрчилгээнд дүрмийн сангийн өөрчлөлтийг хийлгэх	1						1			
<b>ДҮН</b>					<b>2</b>						<b>1</b>			
<b>НИЙТ ДҮН</b>					<b>12</b>	<b>680,990.00</b>	<b>5</b>	<b>670,970.5</b>	<b>1</b>	<b>173.2</b>	<b>1</b>	<b>2,292.5</b>	<b>5</b>	<b>7,553.5</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 06 дугаар сарын 26 № 222/А015045P  
АХГ-2022/348/НА-СТА-ТМ13

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Малын удмын сангийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аж ахуйн нэгж, байгууллага болон малчидтай мал бойжуулах гэрээ хийсэн боловч гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, 2,292,800.00 төгрөгийн төлбөр тооцоог тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6 "... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аж ахуйн нэгж, байгууллага болон малчидтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангуулах, гэрээ дүгнэх;
2. Анхан шатны баримтын бүрдлийг хангаж, төлбөр тооцоог актаар баталгаажуулах, дээрх зөрчлүүдийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
3. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Малын удмын сангийн үндэсний төвийн захирал П.Ганхуяг, Нягтлан бодогч Б. Тунгалаг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЕР ДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
"ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ" ХХК  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ

Ж.БЯМБАЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

W:\0.10.10.20\Bichig\_Kherreg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Газар-215.Docx

0010800750



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

№ 38/A0150458

Улаанбаатар хот

АХГ - 2022/348/НА - СТА - ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Малын удмын сангийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд 2 ажилтанд хувь хүний орлогын албан татварын 173,200.00 төгрөгийн хөнгөлөлтийг давхардуулан тооцсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 "Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ" гэж заасныг тус тус хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Нэр бүхий хоёр ажилтанд давхардуулан тооцсон ХХОАТ-ын хөнгөлөлтийг 173,200.00 /нэг зуун далан гурван мянга хоёр зуун/ төгрөгийг харьяа дүүргийн Татварын хэлтсийн холбогдох дансанд төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Малын удмын сангийн үндэсний төвийн захирал П.Ганхуяг, Нягтлан бодогч Б.Тунгалаг нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁР ДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
"ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ" ХХК  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Ж.БЯМБАЖАВ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264239

\\10.10.10.20\Richig\_Kherreg\Акт\2022\0225 Auditin 4 Газар-34.Docx

901090124